STUDIA ARCHAEOLOGICA
institute of Archaeology, Mongolia Academy of Sciences
DOI: https://doi.org/10.5564/sa.v45i2.3786

Tomus XLV 2024 Fasciculis 7

Жамсранжавын Баярсайхан[1]✉, Жан-Лүүк Хюль[2]

[1]Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн,
Монгол Улс, Улаанбаатар-13330, Энхтай ваны өргөн чөлөө,
Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 дүгээр байр
[2]Баруун Кентакигийн их сургууль
Антропологи ба угсаатны зүйн судалгааны тэнхим
1906 Коллежийн өндөрлөгийн өргөн чөлөө. #61029
Боулин грийн, Кентаки 42101-1029

Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг дахь буган хөшөөнүүд

Хураангуй. Монгол орны баруун хойд бүс нутагт орших Увс аймаг нь эртний түүх, соёлын дурсгалуудаар баялаг. Эдгээрийн дотор янз бүрийн түүхэн үед хамаарах чулуун хөшөө дурсгал олон. Монгол-Америкийн хамтарсан "Баруун Монгол" судалгааны баг тус аймгийн Зүүнхангай сумын нутагт 2015 оноос өнөөг хүртэл археологийн хайгуул, малтлага судалгаа хийж, тус сумын нутаг дахь эртний түүхийн дурсгалуудыг нээн илрүүлж, бүртгэн баримтжуулж, малтан судалж байна. Энэ өгүүлэлд Зүүнхангай сумын нутагт орших өмнө нь судалгааны эргэлтэд орсон 16 болон шинээр бүртгэн баримтжуулсан 16 буюу нийт 32 буган хөшөөг бүхэлд нь нэгтгэн авч үзлээ. Эдгээр буган хөшөөдийн ихэнх нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарах бөгөөд цөөн тооны буган хөшөөд нь амьтны бодит дүрслэлтэй эсвэл бугын хийсвэр дүрслэлтэй буган хөшөөний ангилалд тус тус хамаарна. Зарим буган хөшөөний сийлбэр хонхор хэсэгт зосон будгийн ул мөр маш тодорхой хадгалагдаж үлдсэн байхаас гадна маш том хэмжээтэй нум сум, хос жад зэрэг хэд хэдэн онцлог дүрслэлүүд байна.

Түлхүүр үг: *Увс, Зүүнхангай, Хүрлийн үе, буган хөшөө, жад, нум сум, улаан зос*.

© Ж.Баярсайхан, Жан-Лүүк Хюль 2024
Email: jabayarsaikhan@gmail.com, https://orcid.org/0000-0001-9536-3856

Bayarsaikhan Jamsranjav[1]✉ & Jean-Luc Houle[2]

[1]Institue of Archaeology Mongolian Academy of Sciences,
Building-1, Peace Avenue, Ulaanbaatar-13330, Mongolia
[2]Department of Folk Studies and Anthropology
[2]Western Kentucky University
1906 College Heights Blvd. #61029
Bowling Green, KY 42101-1029

The deer stones in the territory of Zuunkhangai sum, Uvs province

Abstract. Uvs Province, located in the northwestern region of Mongolia, is rich in ancient archaeological and cultural monuments. Among these, numerous stone monuments represent different historical periods. Since 2015, the joint Mongolian-American "Western Mongolia" research project team has been conducting archaeological surveys and excavations in the territory of Zuunkhangai sum, discovering, documenting, and excavating various archaeological sites. This article reviews 32 deer stones, including 16 previously recorded stelae and 16 newly discovered ones from the area of Zuunkhangai sum. Most of these deer stones belong to the category without animal depictions, while a few feature realistic or abstract images of deer. Some of the stones have preserved traces of ochre paint in the carved recesses, as well as distinctive engravings, such as a large bow and arrow and a pair of spears.

Keywords: *Uvs, Zuunkhangai, Bronze Age, Deer Stones, Spear, Bow and Arrow, Red ochre paint.*

Удиртгал

Зүүнхангай сумын нутагт буй буган хөшөөнүүдийг судлах ажил нэлээд хожуу эхэлжээ. Тухайлбал археологич М.Нямбат, Ц.Одбаатар нар 2010 онд анх удаа тус сумын төвийн ойролцоох Их голын дэнж, Хүрдлэгийн ам, Бүлцэнгийн үзүүр зэрэг дурсгалт газруудад буй гурван буган хөшөөний тодорхойлолт, гар зургийг хэвлүүлжээ (Нямбат, Одбаатар 2010:57-66). Үүний дараа дээрх дурсгалт газруудаас гадна сумын төв, Хүйс толгой, Далан булаг зэрэг дурсгалт газруудад буй 16 буган хөшөөний тухай тойм мэдээ, бүрэн бус тодорхойлолт, гар зураг, гэрэл зургийг нийтлүүлжээ (Нямбат, 2016). Үүнээс хойш дурдан буй судалгаанаас тоон болон чанарын хувьд хальсан нэг ч бүтээл хэвлэгдээгүй өдий хүрчээ.

2015 оноос эхлэн өнөөг хүртэл Монгол-Америкийн хамтарсан "Баруун Монгол" судалгааны баг тус сумын нутагт археологийн хайгуул, малтлага судалгаа хийх явцдаа өмнө дурдагдсан буган хөшөөнүүдээс гадна нийт 16 буган хөшөөг шинээр бүртгэн, бүрэн баримтжуулалт хийжээ. Мөн өмнө нийтлэгдсэн дурсгалуудын тодорхойлолт, гар зургийг дахин шинээр үйлдэж, энэхүү судалгаанд нэгтгэн, нийт арван гурван дурсгалт газрын 32 буган хөшөөний судалгааг багтаалаа.

Бүлцэнгийн үзүүрийн дурсгал

Зүүнхангай сумын төвөөс хойш 10 км орчим зайд Бүлцэнгийн үзүүр гэх газар уужим сайхан хөндийд их замын зүүн талд дугуй хүрээтэй хиргисүүр бий. Уг хиргисүүрийн дугуй хүрээний голч 31 х 35 м бөгөөд 2 м орчим өргөн чулуун дараастай. Голын чулуун овоолго 16 м голчтой, 1 м орчим өндөр. Голын чулуун овоолгын захаас хүрээ хооронд зовхисын 50, 124, 210, 304 хэмд чиглэсэн чулуун өрлөг хигээстэй. Орой дээрээсээ ухагдаж намссан ул мөртэй. Уг хиргисүүрийн хүрээний гадна талд баруун хойд талаар тойрон байрлах есөн ширхэг цагариг хэлбэрийн тахилгын байгууламж бий. Харин зүүн өмнө талд унаж, зарим нь хугарсан дөрвөн буган хөшөө, хиргисүүрийн овоолго дээр бас нэг унасан буган

хөшөө буйтай нийлээд бүгд таван буган хөшөө байна. Монгол-Америкийн хамтарсан “Баруун Монгол” судалгааны төслийн баг 2015 онд уг хиргисүүрийн чулуун хүрээний зүүн хойд хэсэгт он цаг тогтоох хэрэглэгдэхүүн илрүүлэх зорилгоор бага хэмжээний сорилын малтлага хийсэн боловч ямар нэгэн эд өлгийн зүйл гараагүй (Баярсайхан нар., 2015: 24-26).

Буган хөшөө №1: Нягтрал сайтай цагаан саарал боржин чулуугаар хийсэн. 214 см өндөр, 19 см өргөн, 79 см зузаан. Өдгөө дээрх хиргисүүрээс холгүй урд талд газарт сул хэвтэж буй. Хөшөөний орой хэсгийг тойруулан өргөн ховилоор, титэм (толгойн боолт Ж.Б) дүрсэлж, үүний дор нүүрэн талд гурван ташуу зураас, зэрэгцээ баруун хажууд дороо үрлэн унжлагатай, дотроо янгирын дүрстэй том цагариг ээмэг, баруун хажууд үрлэн унжлагатай жижиг цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлт тус тус сийлжээ. Үүнээс доош хөшөөний баруун хажуу талын өргөн зайд дөрвөн морь хөллөсөн хоёр дугуйт тэрэг, зүүн хажуу талд дөрвөн хандгай буга дүрсэлсний нэг нь бүсний дор дүрслэгджээ. Хөшөөний тэхий дундуур ганц шулуун ховилоор бүсийг илэрхийлж, бүснээс баруун хажууд байлдааны зээтүү зүүж, зүүн хажууд хоромсоготой нум бүсэнд хавчуулсан байдалтайгаар тус тус сийлжээ (Зураг 1, А). Амьтны бодит дүрслэлтэй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №2: Цагаан саарал боржин чулуугаар хийсэн. 87 см өндөр, 26 см өргөн, 16 см зузаан. Уг хөшөө 1 дүгээр буган хөшөөний урд талд холгүй зайд газарт сул хэвтэнэ. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт гурван ташуу зураас, түүний доогуур хөшөөг тойруулан нарийн ховилоор хүзүүний зүүлт, түүнээс доош дундаас доохнуур нэг шулуун ховилоор бүсийг тус тус сийлжээ. Бүснээс нүүрэн талд хутга бололтой урт гонзгой эд зүүж, баруун хажууд хоромсоготой нум хавчуулсан байдлаар дүрсэлжээ (Зураг 1, Б). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №3: Цагаан саарал боржин чулуугаар хийсэн. 72 см өндөр, 11 см өргөн, 28 см зузаан. 2 дугаар буган хөшөөнөөс зүүнш 5 м орчим зайд газар сул хэвтэнэ. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт гурван ташуу зураас, түүний зэрэгцээ баруун болон зүүн хажууд нэжгээд цагариг ээмэг тус тус сийлжээ (Зураг 1, В). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №4: Бор шаргалдуу боржин чулуугаар хийсэн. 98 см өндөр, 21 см өргөн, 23 см зузаан. 3 дугаар буган хөшөөний ар талд холгүй сул хэвтэнэ. Дундуураа хугарсан, орой дээрээсээ элтэрсэн. Хөшөөний дээд хэсгийг тойруулан дугуй хонхруудаар хүзүүний зүүлт, дундаас доохнуур шулуун ховилоор бүс дүрсэлжээ. Бүснээс нүүрэн талд дугуй толттой, чагтан балтагтай чинжаал хутга зүүж, зүүн хажуу талд хоромсоготой нум бүсэнд хавчуулснаар тус тус сийлжээ. Мөн баруун хажууд бүсний дор байлдааны сүх дүрсэлсэн (Зураг 1, Г). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №5: Цайвар саарал боржин чулуугаар хийсэн. 105 см өндөр, 19 см өргөн, 32 см зузаан. Уг хөшөө нь хиргисүүрийн чулуун овоолго дээр сул хэвтэж байв. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ баруун хажуу талд нэг дугуй хонхор, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлт тус тус сийлжээ (Зураг 1, Д). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Хүрдлэгийн амны дурсгал

Зүүнхангай сумын төвөөс баруун тийш гол өгсөөд 10 км орчим зайд Хүрдлэгийн овооны зүүн бэл, Хар усны голын хойд талын тэгш сайхан дэвсэг газрыг Хүрдлэгийн ам гэнэ. Энд Хүрлийн үеэс лавтай Түрэгийн үе хүртэлх олон тооны дурсгал буй. Эдгээрийн тоонд дугуй хүрээтэй хиргисүүр 4, дугуй намхан дараастай булш 5, дөрвөлжин “хүрз хэлбэр”-ийн тахилгын байгууламжууд, буган хөшөөний тахилгын байгууламж хоёр бүлэг, буган хөшөө 9, Түрэгийн тахилгын дөрвөлжин чулуун хайрцаг бүхий онгон хоёр, хүн чулуу хоёр, мөн ийш тийшээ чиглэлтэй маш олон тооны жижиг зэл чулууд тус тус байна. Энд буй Түрэгийн тахилгын онгоны том нь гадуураа шороон далан, шуудуутай, 420 м орчим урт зэл чулуутай юм. Энд буй буган хөшөөнүүдийн хоёр нь анхны байрлал дээрээ хугарч унасан байдалтай байгаа бол бусдыг нь бүгдийг зөөж, Түрэгийн тахилгын онгоны хашлага, зэл чулуу болгон ашиглажээ. Эдгээр буган хөшөөнүүдийг бид 2015, 2018 онд бүртгэн баримтжуулсан (Баярсайхан нар 2015; 2018).

Буган хөшөө №1: Хөх саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг хөшөө нь Хүрдлэгийн амны дурсгалт газрын баруун хэсэгт хонхойлгон ухсан том дугуй нүхний зүүн талд газарт сул хэвтэнэ. 78 см өндөр, 24 см өргөн, 57 см зузаан. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ баруун болон зүүн хажуу талд нэжгээд цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан олон жижиг хонхруудаар хүзүүний зүүлтийг тус тус дүрсэлжээ. Хүзүүний зүүлтээс доош нүүрэн талд дөрвөн хигээстэй дугуй дүрс (тэрэгний дугуй мэт Ж.Б), баруун хажууд нар буруу эргэлттэй ороомог дүрс, зүүн хажууд тагнай хээтэй таван талт бамбай, түүний хажууд цагариг дүрсээр толийг тус тус сийлжээ. Эдгээрийн доогуур уулан хээтэй бүс урлажээ (Зураг 2, А). Бүсний яг доогуур хөшөө хугарсан бөгөөд ёзоор хэсэг нь хаана байгаа нь тодорхойгүй. Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №2: Саарал боржин чулуугаар урласан. 56 см өндөр, 25 см өргөн, 18 см зузаан. Нэгдүгээр хөшөөнөөс баруун хойш холгүй зайд Түрэгийн тахилгын онгоны зүүн талд босгожээ. Хөшөөний гадаргуу нэлээд элэгдэж, ховхорсон. Өдгөө хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ зүүн хажуу талд цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хүзүүний зүүлтийг илэрхийлсэн цөөн тооны дугуй хонхор дүрсүүд хадгалагдан үлджээ (Зураг 2, Б). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №3: Саарал боржин чулуугаар хийсэн. 94 см өндөр, 15 см өргөн, 35 см зузаан. Уг хөшөөг Хүрдлэгийн амны түрэг том тахилгын онгоны зэл чулуунд ашиглажээ. Хөшөөний тэхий дундуур шулуун ховилоор бүс дүрсэлснээс өөр сийлбэр мэдэгдэхгүй (Зураг 3, А). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №4: Саарал боржин чулуугаар хийсэн. 134 см өндөр, 23 см өргөн, 58 см зузаан. Хөшөөний хугархай хэсэг бөгөөд дээд, доод хэсэг нь хугарч үгүй болсон. Хөшөөг Хүрдлэгийн амны Түрэг онгоны зүүн талын хашлага чулуу болгон ашиглажээ. Хөшөөний баруун хажуугийн өргөн талбайд урт иштэй жад, мөрөн дээрээ цагаригтай байлдааны сүх, ар талд тагнай хээтэй таван талт бамбай, зүүн хажууд 105 см урт хоромсоготой нум, түүний дэргэд нэг адууг тус дүрсэлжээ. Тэдгээрийн доогуур давхар уулан хээтэй өргөн бүс, бүснээс баруун хажууд мөөгөн толттой, чагтан балтагтай хуйтай чинжаал, зүүн хажууд бөгтөрдүү хутга, билүү чулуу тус тус зүүснээр сийлжээ (Зураг 3, Б). Амьтны бодит дүрслэлтэй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №5: Саарал боржин чулуугаар хийсэн. 117 см өндөр, 16 см өргөн, 70 см зузаан. Хөшөөний хугархай хэсэг бөгөөд дээд, доод хэсэг нь хугарч үгүй болсон. Хөшөөг мөн 4 дүгээр буган хөшөөтэй залгуулан Түрэг онгоны зүүн талын хашлага чулуу болгон ашиглажээ. Хөшөөний баруун хажуу талын өргөн талбайд хоёр бугын хийсвэр дүрслэл (бүрэн бус Ж.Б) түүний хажууд урт бариултай жад дүрсэлсэн бөгөөд жадны бариулын хойд төгсгөлд мөөг хэлбэрийн хийц гаргажээ. Нөгөө эсрэг талын өргөн талбайд дөрвөн бугын хийсвэр дүрслэл (мөн бүрэн бус Ж.Б) түүний хажууд бас нэг урт иштэй жад сийлжээ. Хөшөөний нэг талын бугуудыг толгойг доош, нөгөө талын бугуудыг эсрэгээр нь дээш харуулан дүрсэлсэн бөгөөд жадны гилбэрүүдийг мөн бугын толгойн чиглэлд хандуулан сийлжээ (Зураг 3, В). Эл буган хөшөөний хоёр нарийн талд ямар нэгэн дүрслэл мэдэгдэхгүй аж. Бугын хийсвэр дүрслэлтэй хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №6: Саарал боржин чулуугаар хийсэн. 47 см өндөр, 18 см өргөн, 26 см зузаан. Хүрдлэгийн амны түрэг онгоны 420 м гаруй үргэлжлэх урт зэл чулуудын нэг (хойноос 15 дахь зэл чулуу) болгон ашиглажээ. Хөшөөний нэг өргөн талд нар зөв эргэлттэй ороомог дүрс сийлжээ (Зураг 3, Г). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №7: Хөх саарал боржин чулуугаар хийсэн. 46 см өндөр, 16 см зузаан, 29 см зузаан. Хүрдлэгийн амны түрэг онгоны 420 м гаруй үргэлжлэх урт зэл чулуудын нэг (хойноосоо 48 дахь зэл чулуу) болгон ашиглажээ. Хөшөөний нэг талд урт унжлагатай цагариг ээмэг сийлсэн. Өөр ямар нэгэн дүрслэлгүй (Зураг 3, Д). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №8: Саарал боржин чулуугаар хийсэн. 105 см өндөр, 30 см өргөн, 22 см зузаан. Уг хөшөө нь Хүрдлэгийн амны дурсгалт газрын өмнөд хэсэгт тахилгын байгууламжуудын дунд анхны байрлал дээрээ ёроол хэсгээрээ хугарч унасан. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ баруун хажуу талд жижиг унжлагатай цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг

дугуй хонхруудаар хүзүүний зүүлтийг тус тус дүрсэлжээ. Хүзүүний зүүлтээс доош ар талд тагнай хээтэй таван талт бамбай, түүний доогуур хөшөөг тойруулан нэг шулуун ховилоор бүс сийлсэн. Бүснээс баруун хажууд байлдааны сүх, зүүн хажууд дугуй толттой, чагтан балтагтай чинжаал, цагариган толттой охор хутга зэргийг зүүснээр тус тус урлажээ (Зураг 4, А). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №9: Саарал боржин чулуугаар хийсэн. 50 см өндөр. 8 дугаар буган хөшөөний өмнөхөн талд тахилгын байгууламжуудын захад байх буган хөшөөний хугархай хэсэг. Газарт зоолттой байна. Үүнээс үзэхэд анхны байрлал дээрээ байгаа бололтой. Хөшөөнөө шулуун ховилоор дүрсэлсэн бүсний сийлбэр тод харагдана (Зураг 4, Б). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Хужирын улаан толгойн дурсгал

Хүрдлэгийн амнаас хойш 1,7 км зайд Хүрдлэгийн голын зүүн талд Хужирын улаан толгой хэмээх газарт түрэгийн үеийн нэлээд олон тахилгын онгон бий. Эдгээрээс хоорондоо холгүй зайтай хоёр бүлэг тахилгын онгонд хашлага болгон ашигласан гурван буган хөшөө байна. Эдгээр буган хөшөөг 2017 онд бүртгэн баримтжуулсан (Баярсайхан нар, 2017).

Буган хөшөө №1: Саарал боржин чулуугаар хийсэн. 135 см өндөр, 20 см өргөн, 58 см зузаан. Энэ буган хөшөөний хугархай хэсгийг 200 х 200 см, 200 х 190 см хэмжээтэй зэрэгцээ хоёр тахилгын онгоны урд талын онгоны зүүн талын хашлага болгон ашиглажээ. Хөшөөний нэг зүүн хажуугийн өргөн талд дугуй толь, тагнай хээтэй таван талт бамбайн дүрслэл, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан бүс сийлжээ. Уг бүс нь зүүн хажуу болон ар талд уулан хээтэй боловч баруун хажууд тодорхой зайд хоёр талын шулуун ховилоос товойн гарсан шүдлэг өөр хээгээр чимэглэгджээ. Бүснээс баруун хажууд урт иштэй сүх, зүүн хажууд мөөгөн толттой, чагтан балтагтай чинжаал, хоромсоготой нум зүүснээр тус тус сийлжээ (Зураг 5, А). Хөшөөний нүүрэн талд ямар нэгэн дүрслэл хадгалагдаж үлдээгүй. Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №2: Саарал боржин чулуугаар хийсэн. 102 см өндөр, 21 см өргөн, 36 см зузаан. Уг хөшөөг 1 дүгээр буган хөшөө буй тахилгын онгоноос хойш холгүй зайд дөрвөн зэрэгцээ тахилгын онгон буй. Тэдгээрийн хамгийн урд талын 460 х 500 см хэмжээтэй онгоны урд талын хашлагад уг буган хөшөөг ашиглажээ. Хөшөөний нүүрэн талд хоёр ташуу зураас, зэрэгцээ зүүн хажуу талд охор унжлагатай цагариг ээмэг, түүний дор тагнай хээтэй таван талт бамбай тус тус дүрсэлжээ. Хөшөөний дунд хэсэгт давхар шулуун ховилоор бүс сийлж, бүснээс зүүн хажууд хоромсоготой нум зүүснээр урлажээ (Зураг 5, Б). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №3: Саарал боржин чулуугаар хийсэн. 140 см өндөр, 17 см өргөн, 50 см зузаан. Эл буган хөшөөг 2 дугаар буган хөшөө ашигласан тахилгын онгоны зүүн урд талын хашлагад ашиглажээ. Хөшөө дундуураа ташуу хугарсан. Нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, зэрэгцээ баруун хажууд цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан дугуй хонхруудаар хүзүүний зүүлтийг тус тус дүрсэлжээ. Хүзүүний зүүлтээс доош зүүн хажуу талд дугуй толь, тагнай хээтэй таван талт бамбай, тэдгээрийн доогуур шулуун ховилоор бүс сийлжээ. Бүснээс баруун хажууд билүү чулуу, зүүн хажууд мөөг хэлбэрийн толттой, чагтан балтагтай чинжаал зүүснээр урлажээ (Зураг 5, В). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Гялгарын бэлийн дурсгал

Олон үеийн бууц суурины давхаргатай Гялгарын өврийн өвөлжөөнөөс баруунш Хүрдлэгийн гол руу, урагш Хар усны гол руу тохойрч орсон налуу талыг Гялгарын бэл гэнэ. Гялгарын бэлд энд тэнд тарж байрласан Хүрлийн үеийн хиргисүүрүүд, дугуй намхан дараастай булш, Түрэгийн тахилгын онгон зэрэг дурсгалууд бий. Эдгээрээс түрэгийн үеийн хоёр тахилгын онгонд хүн чулуу болгон ашигласан хоёр буган хөшөө байна.

Буган хөшөө №1: Ягаан боржин чулуугаар хийсэн. 97 см өндөр, 35 см өргөн, 20 см зузаан хэмжээтэй. Уг буган хөшөөг хожим зөөвөрлөн авчирч, Түрэгийн тахилгын онгоны зүүн талд хүн чулуу болгон босгосон боловч ёроол хэсгээрээ

хугарч, газарт унажээ. Газарт зоолттой буй ёзоорын өндөр 18 см. Хөшөөний хажууд буй тахилгын онгон 330х290 см хэмжээтэй. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний доогуур хөшөөг тойруулан цөөн тооны дугуй хонхроор хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Нүүрэн талд хүзүүний зүүлтийн дор үл танигдах амьтны их бие, хөлийн дүрслэл байх боловч толгой хэсэг нь баларч мэдэгдэхгүй болсон. Хөшөөний доод хэсэгт хоёр давхар шулуун ховилоор бүс, баруун хажууд бүсний дээхнээ дугуй толь тус тус сийлжээ. Мөн хөшөөний зүүн хажуу болон ар талыг дамнуулан хүзүүний зүүлтийн доохнуур өргөн ховил сийлсэн нь хожим Түрэгийн үед хүн чулуу болгон засахыг оролдсоны ул мөр бололтой (Зураг 6). Уг хөшөөг 2015 онд илрүүлэн олсон бөгөөд амьтны дүрслэлгүй буган хөшөөний төрөлд хамаарна (Баярсайхан нар., 2015).

Буган хөшөө №2: Бор саарал боржин чулуугаар урласан. 126 см өндөр, 25 см өргөн, 32 см зузаан хэмжээтэй. Уг буган хөшөөг мөн хожим зөөвөрлөн авчирч, ёроол хэсэгт нь хүний толгой нэмж сийлэн Түрэгийн тахилгын онгонд хүн чулуу болгон ашиглажээ. Биднийг анх олоход 440х443 см хэмжээтэй дөрвөлжин тахилгын онгоны зүүн талд унаж, тэн хагас нь газарт булагдсан байв. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт гурван ташуу зураас, түүний зэрэгцээ зүүн хажуу талд цагариг ээмэг, баруун хажуу талд жижиг үрлэн унжлагатай цагариг ээмэг тус тус дүрслээд, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Хүзүүний зүүлтээс доош баруун хажууд нар буруу эргэлттэй ороомог дүрс, зүүн хажууд дугуй толь, түүнээс доош хөшөөний тэхий дундуур зэрэгцээ хоёр шулуун ховилоор бүс сийлжээ. Бүснээс нүүрэн талд хутга, баруун хажууд байлдааны сүх, зүүн хажууд хоромсоготой нум, түүний хажууд, билүү чулуу тус тус зүүснээр дүрсэлжээ (Зураг 7). Өмнө дурдсанчлан хөшөөний баруун хажуугийн доод хэсэгт хожим Түрэгүүд хүний нүүр нэмж сийлээд, буган хөшөөний толгойг уруу харуулан газарт зоосон байжээ. Уг хөшөөг 2023 онд илрүүлэн олсон бөгөөд амьтны дүрслэлгүй буган хөшөөний төрөлд хамаарна (Баярсайхан нар, 2023).

Цавдан нуурын арын дурсгал

Зүүнхангай сумын төвөөс зүүн урагш 14 км зайд, Цавдан нуурын ард жижиг дэвсэг толгой дээр Хүрлийн үеийн бүлэг дурсгал байна. Үүнд, дугуй хүрээтэй хоёр хиргисүүр, дөрвөлжин хүрээтэй хоёр хиргисүүр, он цаг нь тодорхойгүй цагариг хэлбэрийн чулуун дараастай гурван булш, битүү чулуун дараастай дугуй жижиг байгууламж хоёр тус тус бий. Эдгээрийн хамгийн зүүн урд талд олон арван тахилгын байгууламжтай, 42 х 33 м дөрвөлжин хүрээтэй, голдоо 2 м өндөр, 18 м голчтой чулуун овоолго бүхий том хиргисүүрийн баруун талд тахилгын байгууламжуудын дунд, хуучин суурин дээрээ унаж газарт булагдсан нэг буган хөшөө байна. Түүнээс гадна хамгийн хойд талын 28 м голчтой дугуй хүрээтэй хиргисүүрийн өмнө талд хүрээнээс ялимгүй гадагш, газарт унаж булагдсан өөр нэг буган хөшөө байв. Уг дурсгалт газрыг 2023 онд бүртгэн баримтжуулсан (Баярсайхан нар, 2023).

Буган хөшөө №1: Саарал боржин чулуугаар хийсэн. 272 см өндөр, 24 см өргөн, 42 см зузаан. Эл буган хөшөө нь битүү чулуун дараастай 8-10 ширхэг дугуй тахилгын байгууламжийн дунд хуучин суурин дээрээ газарт унаж, булагдсан байв. Хөшөөний булагдсан хөрсийг малтаж гарган бүрэн баримтжуулалт хийлээ. Хөшөөний нүүрэн талын нарийн хэсэгт гурван буга, баруун хажууд гурван буга, ар талд хоёр буга, зүүн хажууд дөрвөн буга буюу нийт 12 бугыг бүгдийг нь дээш цоройлгон хийсвэр байдлаар дүрсэлжээ (Зураг 8, А). Хөшөөний гадаргуу нэлээд элэгдэж гэмтсэнээс болж ар тал болон зүүн хажуу талд чухам анх хэдэн буга дүрсэлснийг тогтооход бэрхшээлтэй болжээ. Эдгээр бугаас өөр дүрслэлгүй. Бугын хийсвэр дүрслэлтэй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №2: Саарал боржин чулуугаар хийсэн. 151 см өндөр, 24 см өргөн, 34 см зузаан. Уг хөшөө нь эндхийн хамгийн хамгийн хойд талд буй дугуй хүрээтэй хиргисүүрийн өмнө талд газарт булагдсан байв. Хөшөөний эргэн тойрон хөрсийг малтаж эргүүлж нягтлан шалгасан боловч ямар нэгэн сийлбэр дүрслэл мэдэгдсэнгүй. Уг хөшөөний хэлбэр, засалт, байгаа байршлыг харахад буган хөшөө бололтой. Гагцхүү он цагийн уртад гадаргуу дээрх сийлбэр баларч үгүй болжээ (Зураг 8, Б). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Хүйс толгойн дурсгал

Зүүнхангай сумын төвөөс хойш 30 км гаруй зайд Улаан хясааны голын зүүн талд Хүйс толгой хэмээх жижиг толгойн зүүн болон хойд талаар намхан чулуун дараастай дугуй булшнууд, Сагсай булш зэрэг байхаас гадна нэг том буган хөшөө бий. Хэдийгээр уг буган хөшөөний тодорхойлолт, гар зураг өмнө хэвлэгдсэн боловч сайжруулах шаардлага байсан тул бид уг буган хөшөөний гар зураг, тодорхойлолтыг 2015 онд шинэчлэн хийсэн юм (Баярсайхан нар, 2015).

Буган хөшөө №1: Саарал боржин чулуугаар хийсэн. 230 см өндөр, 20 см өргөн, 94 см зузаан. Цөөн тооны цагариг хэлбэрийн тахилгын байгууламжийн хажууд босоогоороо байна. Хөшөөний нэг өргөн талд гурван бугыг толгойгоор нь доош хандуулан хийсвэрлэн дүрсэлж, дээд талын бугын хошуун дор нэг сул эврийн хэсэг, нөгөө эсрэг талын өргөн талд хоёр бугыг толгойгоор нь дээш хандуулан хийсвэр байдлаар сийлсэн. Энэ хоёр бугын доод талын бугын цээжин дор нэг сул эвэр нэмж урлажээ. Хоёр нарийн талд ямар нэг дүрслэл харагдахгүй аж (Зураг 9). Бугын хийсвэр дүрслэлтэй буган хөшөөний ангилалд хамаарна.

Хөх голын дурсгал

Хүйс толгойгоос хойш 10 км орчим зайд Хөх голын ар биед нэг нүсэр том хиргисүүр бий. Уг хиргисүүр нь 115 м голчтой дугуй хүрээний төвд 50 м голчтой, 10 м орчим өндөр чулуун овоолготой, хүрээний гадуур олон арван битүү чулуун дараастай дугуй хэлбэрийн тахилгын байгууламжтай. Түүнээс холгүй зүүн урагшаа хоорондоо 200 гаруй метр зайтай хоёр бүлэг Түрэг тахилгын онгонд тус бүр нэг буган хөшөөг хүн чулууны оронд босгожээ.

Буган хөшөө №1: Саарал боржин чулуугаар хийсэн. 40 см өндөр, 34 см өргөн, 27 см зузаан. Уг буган хөшөөг зэрэгцээ хоёр тахилгын онгоны хойд талын онгоны зүүн талд босгожээ. Хөшөөний нүүрэн талд ташуу гурван зураас, түүний доогуур хөшөөг тойруулан зууван дугуй хонхруудаар хүзүүний зүүлтийг дүрслэн сийлжээ (Зураг 10). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №2: Саарал боржин чулуугаар хийсэн. 63 см өндөр. 1 дүгээр буган хөшөөнөөс зүүнш 210 гаруй метр зайд буй Түрэгийн үеийн зэрэгцээ дөрвөн тахилгын онгоны хойноосоо хоёр дахь тахилгын онгоны зүүн талд босгосон хугархай буган хөшөө юм. Уг хөшөөнд шулуун ховилоор бүс дүрсэлсэн тодхон харагдах бөгөөд бүсний дор хутга болов уу гэмээр урт гонзгой дүрс ажиглагдана (Зураг 11). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Зүүнхангай сумын төвийн дурсгал

Зүүн хангай сумын төвд Зоригт бэйл Р.Наваанцэрэнгийн хөшөөний дэргэд сул хэвтэх буган хөшөөг нутгийнхан Лу жанжин гүний бөхийн өргөсөн чулуу гэж домоглон ярих боловч яг хаанаас хэн, хэзээ, хэрхэн авчирсныг тодорхой мэдэх хүнгүй.

Буган хөшөө №1: Саарал боржин чулуугаар урласан. 163 см өндөр, 23 см өргөн, 40 см зузаан. Хөшөөний оройг мөлийлгөн засаж, баруун хажуу талын дээд хэсэгт цагариг ээмэг, түүний доогуур хөшөө тойруулан олон хонхруудаар хүзүүний зүүлт сийлжээ. Хүзүүний зүүлтийн ар шилэн хүзүүн дээр бусдаас дундаа хонхортой том дугуй цагариг дүрсэлсэн байна (Зураг 12).

Дөрөлжийн хөшөөтийн дурсгал

Зүүнхангай сумын Даланбулаг багийн төвөөс урагш 10 км зайд Хойд баян улаан уулын ар хөндийд хоёр бүлэг тахилгын байгууламжуудын хажууд нэг босоо (№1), нэг унасан буган хөшөө (№2) байна. Уг дурсгалт газарт буй хоёр буган хөшөөний гэрэл зургийг анх археологич М.Нямбат “Тариат” гэдэг нэрээр хэвлүүлсэн (Нямбат, 2016) боловч орон нутгийн хүмүүс бүгд Дөрөлжийн хөшөөт хэмээн нэрлэж буй тул энэ нэрийг баримтлав.

Буган хөшөө №1: Саарал боржин чулуугаар хийсэн. 115 см өндөр, 28 см өргөн, 31 см зузаан. Хөшөөний нүүрний зүг чигийг харахад анхны байрнаас хөдөлж, хожим дахин босгосон бололтой. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, зэрэгцээ баруун хажууд цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлт тус тус сийлжээ. Хүзүүний зүүлтээс доош баруун хажуу талд ганц дугуй толь, түүний дор бүс тойруулан сийлсэн нь баруун хажууд болхидуу уулан хээтэй, бусад талуудад ганц шулуун ховилоор дүрслэгджээ. Бүснээс баруун хажууд сүх зүүснээр

урласан. Бүсний дор ар талд тагнай хээтэй таван талт бамбай, зүүн хажууд нум сумын дүрс тус тус сийлсэн (Зураг 13, А). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №2: Бор саарал боржин чулуугаар хийсэн. 221 см өндөр, 23 см өргөн, 39 см зузаан. Хөшөө дундуураа хугарсан. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт ташуу гурван зураас, зэрэгцээ баруун хажууд цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлт тус тус сийлжээ. Хүзүүний зүүлтээс доош нүүрэн талд ганц дугуй толь, түүний дор хөшөөг тойруулан өвөрмөц хээ чимэглэл бүхий бүс дүрсэлсэн байна. Уг бүс нь нүүрэн тал болон баруун хажууд голдоо товруутай (хонхойлгон сийлсэн) ханан хээгээр чимэглэгдсэн бол ар болон зүүн хажуу талд зөвхөн цувраа товруу (хонхор дүрсээр илэрхийлсэн) чимэгтэйгээр сийлэгджээ. Бүснээс нүүрэн талд мөөгөн толттой, чагтан балтагтай чинжаал, баруун хажууд урт иштэй байлдааны сүх, зүүн хажууд хутга зүүснээр тус тус урлажээ (Зураг 13, Б). Уг хөшөөний бүсний зарим хэсэгт болон сүхний дүрсний хонхор сийлбэрт улаан зосоор будсан ул мөр маш тодорхой хадгалагдан үлджээ. Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Далан булагийн дурсгал

Зүүнхангай сумын Далан булаг багийн төвөөс баруун урагш 1.6 км зайд нэг босоо буган хөшөө байна. Түүнээс холгүй урд талд бүлэг тахилгын байгууламж буй нь энэ буган хөшөөнийх бололтой. Анх тэнд босгосон байх. Эдүгээ буй газарт ялимгүй зөөгдсөн бөгөөд хөшөөний зүг чигийг ажиглахад сүүлд энэ газарт дахин босгосон болохыг илтгэнэ.

Буган хөшөө №1: Улбар шар туяатай саарал боржин чулуугаар урлажээ. 121 см өндөр, 26 см өргөн, 39 см зузаан. Уг хөшөөний баруун хажуугийн дээд хэсэгт цагариг ээмэг түүний доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлтийг дүрсэлжээ. Хүзүүний зүүлтийн дор баруун хажуугаас ар тал руу дамнуулан нэгэн буга, түүний өехий дор байлдааны сүх тус тус сийлсэн байна. Бугын эврийг нэлээд бодитой дүрсэлсэн боловч хошууг шувуу мэт урт дүрсэлсэн нь хийсвэр байдлаар илэрхийлэхийг зорьсны шинж бололтой. Хөшөөний доод хэсгээр өргөн ховилоор бүс урлаж, бүснээс зүүн хажууд нум зүүснээр сийлжээ. Мөн энэхүү нум зүүсэн талд бүсийг болхидуу уул хээгээр чимэглэхийг оролдсон аж. Баруун хажууд бүсний дор бас нэг жижиг бугын эвэр, биеийн зарим хэсэг мэдэгдэх боловч бусад хэсэг нь доош газарт булагдсан тул бүрэн тодорхой харж чадсангүй (Зураг 14). Бугын хийсвэр дүрслэлтэй буган хөшөөний ангилалд хамаарна.

Их голын дэнж-1 дурсгал

Сумын төвөөс зүүн урагш 1 км орчим зайд, Их голын урд дэнж дээр их замын хажууд нэг буган хөшөө, түүнээс хойд зүгт 43 м зайд тахилгын байгууламж бололтой хэсэг чулуун байгууламж бий. Энэ нь буган хөшөөг анх босгосон газар бололтой.

Буган хөшөө №1: Цайвар саарал боржин чулуугаар хийсэн. 185 см өндөр, 29 см өргөн, 41 см зузаан. Орой хэсгээсээ доош 43 см орчимд хөндлөн хугарсан. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, зэрэгцээ зүүн хажууд цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг зууван дугуй хонхруудаар хүзүүний зүүлтийг тус тус дүрсэлжээ. Түүнээс доош нүүрэн талд зэрэгцээ хоёр жижиг дугуй хонхор, баруун хажуу талд урт иштэй жад, дугуй толь, зүүн хажуу талд хоромсоготой нум, ар талд тагнай хээтэй таван талт бамбай, тэдгээрийн доогуур өргөн шулуун ховилоор бүс тус тус сийлжээ. Бүснээс нүүрэн талд цагариг толттой хутга, баруун хажууд чагтан балтагтай том чинжаал, зүүн хажууд байлдааны сүх, билүү чулуу тус тус зүүснээр дүрсэлсэн байна (Зураг 15). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Их голын дэнж - 2 дурсгал

Зүүнхангай сумын төвөөс зүүн зүгт 1 км зайд, Их голын урд дэнж дээр 98 м голчтой, 2 м өргөн чулуун дараас бүхий дугуй хүрээтэй, голын чулуун овоолго нь 25 м голчтой, 3 м орчим өндөр томоохон хиргисүүр бий. Уг хиргисүүрийн голын чулуун овоолгоос хүрээ рүү холбон нарны цацраг эсвэл дугуйн хигээс мэт өрсөн олон тооны чулуун өрлөгтэй. Эдгээр өрлөг чулууд нь зүүн болон зүүн урд хэсгээрээ тод харагдах бөгөөд бусад хэсгээрээ нэлээд бүдэг харагдана. Дугуй хүрээний гадуур эргэн тойрон олон тооны цагариг хэлбэрийн тахилгын байгууламжтай. Үүнээс гадна хиргисүүрийн чулуун овоолгын баруун урд

ёроолд нэг буган хөшөө сул хэвтэнэ. Уг дурсгалт газрыг 2023 онд бүртгэн баримтжуулж, судалсан (Баярсайхан, 2023).

Буган хөшөө №1: Хөх саарал боржин чулуугаар урласан. 114 см өндөр, 33 см өргөн, 29 см зузаан. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, зэрэгцээ баруун болон зүүн хажууд нэжгээд цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан олон зууван дугуй хонхруудаар хүзүүний зүүлтийг тус тус дүрсэлжээ. Баруун хажуу талын цагариг ээмэгний голд нэг жижиг хонхор гаргажээ. Хүзүүний зүүлтээс доош нүүрэн талд дугуй толттой чагтан балтагтай, хуйтай чинжаал, зүүн хажууд хоромсоготой нум, ар талд тагнай хээтэй таван талт бамбайг тус тус сийлжээ (Зураг 16). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Тэгш буянтын хөндийн дурсгал

Зүүнхангай сумын төвөөс Завхан аймгийн Тэс сум явдаг замаар 16 км орчим явахад Тэгш буянтын уудам сайхан хөндийд их замын хажууд нэгэн том хиргисүүр бий. Уг хиргисүүр нь 111 м голчтой, 4-5 м өргөн чулуун дараас бүхий дугуй хүрээтэй, голын чулуун овоолго нь 30 м голчтой, 5 м өндөр бөгөөд бүхэлдээ 0,9 га талбай эзэлнэ. Хиргисүүрийн хүрээний гадна зүүн хойд талд 8 м голчтой, чулуун дараас бүхий дугуй булш бий. Мөн хүрээний гадна баруун өмнө талд хоорондоо холбоотой 2.5 м орчим голчтой, чулуун дараастай хоёр дугуй хэлбэрийн чулуун байгууламжтай. Харин зүүн өмнө талд хүрээнээс гадагш 16 м зайд нэг босоо буган хөшөө (№1), 22 м зайд газарт унаж булагдсан өөр нэг буган хөшөө хөшөө (№2) байна. Уг дурсгалт газрыг 2023 онд илрүүлэн, бүртгэн баримтжуулжээ (Баярсайхан нар., 2023).

Буган хөшөө №1: Саарал боржин чулуугаар хийсэн. 50 см өндөр, 17 см өргөн, 53 см зузаан. Уг хөшөөний дээд хэсэгт нүүрэн талаас хоёр хажуу тал руу давсан нарийн ховилоор хүзүүний зүүлт дүрсэлсэн байх бөгөөд зарим газраа элэгдэж баларчээ. Харин хөшөөний ар шилэнд хүзүүний зүүлтийн үргэлжлэл байна. Мөн хөшөөний зөвхөн баруун хажуу талд шулуун бүс, түүнээс зүүлттэй байлдааны сүхний дүрслэл хадгалагдан үлджээ (Зураг 17, А). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Буган хөшөө №2: Саарал боржин чулуугаар урласан. 93 см өндөр, 23 см өргөн, 29 см зузаан. Газарт унаж булагдсан байсан. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт гурван ташуу зураас, доод хэсгээр хөшөөг тойруулан шулуун ховилоор бүс дүрсэлж, бүснээс нүүрэн талд дугуй толттой, чагтан балтагтай, хуйтай чинжаал зүүснээр сийлжээ (Зураг 17, Б). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд хамаарна.

Судалгааны хэлэлцүүлэг

Зүүнхангай сумын нутаг дахь буган хөшөөнүүдийн ихэнх нь буюу 23 (72%) нь Хар усны гол, Их голын сав дагуу байна. Үлдсэн цөөн хэдэн хөшөө нь Цавдан нуур, Цагаан нуур, Хөх голын сав газарт бий. Чингэхдээ алсын харууцтай дэнж дэвсэг, энгэр бэл, эсвэл өргөн сайхан хөндийг сонгон босгожээ (Зураг 18). Үүнээс үзэхэд газар сонголтын хувьд бусад бүс нутагт тархсан буган хөшөөнүүдийн байршил зүйгээс ялгаагүй аж. Эдгээрээс 13 буган хөшөөний анхны байрлалыг тодорхойлох боломжгүй бөгөөд хожим Түрэгүүд тахилгын онгонд дахин ашиглажээ. Гэвч эдгээр хөшөөнүүдийг ашиглахдаа тэдгээр тахилгын онгоноос холгүй орших Хүрлийн үеийн дурсгалт газраас зөөж авчирсан болов уу гэж бид таамаглаж байна.

Увс аймгийн Зүүнхангай сум бол буган хөшөөний ерөнхий тархалтын хойд бүс нутагт хамаарна. Эл бүс нутагт буй 32 буган хөшөөг 2017 онд шинээр хийсэн (Баярсайхан, 2017) ангиллаар авч үзвэл 27 (85%) нь амьтны дүрслэлгүй, 2 (9%) нь амьтны бодит дүрслэлтэй, 3 (6%) нь бугын хийсвэр дүрслэлтэй буган хөшөөд байна. Амьтдын холимог дүрслэлтэй буган хөшөөд огт байхгүй аж (Зураг 19). Үүнээс үзэхэд уг бүс нутагт амьтны дүрслэлгүй буган хөшөө давамгай тархсан нь эрт үед энэ төрлийн буган хөшөөг бүтээх дэг жаяг, уламжлал түлхүү байсныг гэрчилнэ. Хөшөөнүүдийн өндөр нь 40-272 см-ийн хооронд байх бөгөөд дундаж нь 115 см хэмжээтэй. Эдгээр буган хөшөөнүүдийг ангилал бүрээр нь дундаж өндрийг тооцоход бугын хийсвэр дүрслэлтэй дөрвөн хөшөөний дундаж 185 см, амьтны бодит дүрслэлтэй гурван хөшөөний дундаж 174 см, амьтны дүрслэлгүй 26 хөшөөний дундаж 100.8 см. Үүнээс үзэхэд бугын хийсвэр дүрслэлтэй буган хөшөөнүүд болон амьтны бодит дүрслэлтэй буган хөшөөд нь амьтны дүрслэлгүй буган хөшөөнүүдөөс илүү өндөр, том хэмжээтэй (Зураг 20) бөгөөд энэ нь өмнө хийсэн судалгааны

үр дүнтэй нийцэж байна (Баярсайхан, 2017). Тухайлбал бугын хийсвэр дүрслэлтэй Цавдан нуурын арын буган хөшөө нь хамгийн өндөр буюу 272 см байна.

Буган хөшөөнүүдийн дүрслэлийн онцлогуудыг авч үзвэл хэд хэдэн сонирхолтой шинж тэмдэг ажиглагдана. Тухайлбал, эдгээр 32 буган хөшөөнөөс ганцхан хөшөөнд титэм дүрслэгджээ. Энэ нь Бүлцэнгийн үзүүрийн морин тэрэг бүхий онцгой дүрслэлтэй 1 дүгээр буган хөшөө юм. Уг хөшөө 214 см өндөр бөгөөд нэг талдаа дөрвөн морь хөллөсөн морин тэрэг, нөгөө талдаа дөрвөн хандгай буга, ээмэгний цагариг дотор янгирын дүрслэлтэй. Үүнээс үзэхэд уг хөшөө болон, түүний хажууд буй хиргисүүр нь Хүрлийн сүүл үед энэ бүс нутагт амьдарч байсан нэгэн томоохон язгууртанд зориулсан дурсгал болохыг тодорхой илтгэнэ.

Энэ бүс нутагт буй бугын хийсвэр дүрслэлтэй цөөн тооны хөшөөд нь Монголын бусад бүс нутагт буй ижил төрлийн буган хөшөөнүүдийн нэгэн адил нүүрэн дээрээ ташуу зураасны дүрслэлгүй байхад амьтны дүрслэлгүй 26 хөшөөний 16 нь 2-3 ташуу зураастай, 6 нь ташуу зураасгүй, 4 нь тодорхойлох боломжгүй байна. Мөн нийт 32 хөшөөнөөс 16 нь ээмэгний дүрслэлтэй. Эдгээрээс зүүн хажуудаа ганц ээмэгтэй 3, баруун хажуудаа ганц ээмэгтэй 8, хоёр талдаа ээмэгтэй 5, ээмэг дүрслээгүй 10, тодорхойлох боломжгүй зургаан буган хөшөө тус тус байна. Хүзүүний зүүт дүрсэлсэн 18, дүрслээгүй 9, тодорхойлох боломжгүй таван буган хөшөө буй. Хүзүүний зүүлтийг зөвхөн хоёр буган хөшөөнд шулуун ховилоор дүрсэлсэн бол бусад бүх тохиолдолд зууван дугуй сувс хэлбэртэй сийлжээ (Зураг 21).

Бидний судалсан эдгээр 32 буган хөшөөнд буй бусад зэр зэвсэг, эд зүйлсийн дүрслэлүүдийн хувьд буган хөшөөний соёлын хүрээн дэх түгээмэл зүй тогтлоос онцгой ялгарах зүйлс бага боловч тодруулан дурдмаар хэд хэдэн онцлог бий (Зураг 22). Тухайлбал, Хүрдлэгийн амны 4 болон 5 дугаар буган хөшөө, Их гол-1 дурсгалт газрын буган хөшөөнд хурц гилбэртэй, урт иштэй жад сийлжээ. Ялангуяа Хүрдлэгийн амны 5 дугаар буган хөшөөнд хоёр жад дүрсэлсэн нь уг соёлын хүрээн дэх анхны тохиолдол юм. Эдгээрээс гадна ердөө дөрвөн хөшөөнд буюу Хөвсгөлд гурав, Баянхонгорт нэг буган хөшөөнд тус тус жад дүрсэлсэн байдаг (Баярсайхан, 2017: 183).

Мөн бамбай сийлсэн 11 буган хөшөөний 6 нь ар талд, 5 нь зүүн талд дүрслэгджээ. Эдгээр хөшөөнүүдийн зөвхөн 1 нь бугын хийсвэр дүрслэлтэй, 1 нь амьтны бодит дүрслэлтэй, бусад нь бүгд амьтны дүрслэлгүй хөшөөнүүд байна. Чингэхдээ гурван тохиолдолд бамбай зүүн талд тольтой хамт дүрслэгджээ. Эдгээр хөшөөд нь бүгд амьтны дүрслэлгүй буган хөшөөнүүд бөгөөд оршин буй газрын хувьд өөр хоорондоо холгүй буюу Хүрдлэгийн ам, Хужирын улаан толгойн дурсгалт газарт байна. Энэ тодорхой нэгэн зан үйл гүйцэтгэгчийн юм уу эсвэл урлаачийн шийдэл, онцлогийг харуулж байж болох юм. Бамбайн дүрсийг ихэнхдээ буган хөшөөний ар талд дүрсэлдэг уламжлалтай (Баярсайхан, 2017; 2022).

Үүний нэгэн адил хоромсоготой нум дүрсэлсэн 11 буган хөшөө буйгаас зүүн талдаа нумтай 9, баруун талд нумтай 2 хөшөө буй. Эдгээрээс хамгийн сонирхолтой нь Хүрдлэгийн амны 4 дүгээр буган хөшөөний нэг талд адууны хамт дүрслэгдсэн 105 см урт хоромсоготой нум юм. Энэ нь өдгөө буган хөшөөний соёлд бүртгэгдээд буй хамгийн том, урт нумын дүрс болж байна. Үүнтэй төстэй боловч ялимгүй богино буюу 80 см урт хоромсоготой нум дүрсэлсэн нэгэн хөшөө Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг Хар говийн 2 дугаар буган хөшөөнд бий (Ковалев, Эрдэнэбаатар, 2021: 41).

Өөр нэг онцлог дүрслэл бол Хүрдлэгийн амны 1 болон 6 дугаар буган хөшөөнд дүрсэлсэн ороомгууд юм. Ийм ороомог дүрслэл өнөөгийн байдлаар буган хөшөөний соёлд 20 орчим бүртгэгджээ. Утга бэлгэдлийн хувьд судлаачид янз бүрийн саналтай байдаг ба нэгдсэн ойлголтод хүрээгүй хэвээр байна. Хүрдлэгийн амны 1 дүгээр хөшөөнд дүрслэгдсэн дөрвөн хигээстэй тэрэгний дугуй мэт дүрс нь мөн л ховор дүрс. Үүнтэй төстэй боловч олон хигээстэй дугуйн дүрс Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Сөртийн дэнжийн нэгэн буган хөшөөнд бий (Баярсайхан, 2017:115-116).

Нийт 32 буган хөшөөний 20 нь бүстэй, 10 нь бүсгүй, 2 нь тодорхойлох боломжгүй байв. Бүсний дүрслэлтэй 20 буган хөшөөний 13 нь дан шулуун, 3 нь давхар шулуун, 4 нь уулан хээтэйгээр дүрслэгджээ (Зураг 23).

Зүүнхангай сумын буган хөшөөнүүдөөс хамгийн сонирхолтой ул мөрийг хадгалж үлдсэн дурсгал бол Дөрөлжийн хөшөөтийн 2 дугаар

буган хөшөө юм. Уг хөшөөний бүсний зарим хэсэг болон сүхний дүрсний хонхор сийлбэрт улаан зосоор будсан аж (Зураг 24). Уг буган хөшөө энэ талаараа газар унаж, булагдсан учир эртний зосон будаг харьцангуй сайн хадгалагдан үлджээ.

Өмнө нь Орос судлаач А.А.Тишкин Монгол Алтайн зарим буган хөшөө (Тишкин, 2013а: 81, 88; 2013б: 226), Ю.Н.Есин нар Монголын төв нутаг дахь Хойд Тамирын голын сав дагуух болон Жаргалантын амны зарим буган хөшөөнд хадгалагдаж үлдсэн зосны талаар тус тус судалжээ (Esin et al., 2017: 79-89). Буган хөшөөн дээр хадгалагдаж үлдсэн энэхүү эртний будгийг Минусын хотгорын Окуневийн соёлын хөшөөнүүдийн зосны найрлагад үндэслэн их хэмжээний төмрийн исэл агуулсан гематит (hematite) хэмээх эрдэс чулуулаг, эсвэл зос ашигласан гэж таамагладаг. Дурдсан судлаачид Хойд Тамирын зарим буган хөшөөнүүдөөс холгүй гематит эрдэс чулуулгийн илэрц буйг тогтоож, энэ нь буган хөшөөнүүдийг будсан будгийн эх сурвалж байж болох юм гэж үзсэн (Esin et al, 2017, 87). Үүнээс гадна 2023 онд Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Хөшөөн чулууны дурсгалт газраас буган хөшөө хийх үйл явц, зосон будгийн баримттай холбоотой чухал баримт болох чулуун алх цохиур, нүдүүр, билүү, зүлгүүр, будгийн жижиг чулуун сав зэргийг илрүүлсэн (Идэрхангай нар, 2023: 154). Дурдан буй баримтууд болон Дөрөлжийн хөшөөтийн буган хөшөөнөөс бидний илрүүлсэн эртний зосон будаг нь Хүрлийн үеийн буган хөшөөг бүтээгчдийн урлахуйн ухаан төдийгүй ертөнцийг үзэх үзлийн хөдөлшгүй баримт хэрэглэгдэхүүн болж байна. Агуйн хана туурга, уул хад, хөшөө чулуу, булшны хана хашлага дээр зосоор зурах уламжлал нь Евроазид маш эрт үеэс дэлгэрсэн зан үйлийн нэг болохыг археологийн олон баримтууд гэрчилдэг. Минусын хотгор дахь Окуневийн соёлын (НТӨ 2700-1800) чулуун хөшөөнүүдийн сийлбэрийг мөн улаан зос, хар нүүрсээр өнгө гарган буддаг зан үйл буй нь бүс нутгийн хүрээн дэх хамгийн эртний бөгөөд харьцуулан судлах боломжтой эх сурвалж юм (Есин и др., 2014: 79-88). Буган хөшөөг ийнхүү зосдодог зан үйл нь эртний хүмүүс шүтлэг, бөө мөргөлийн үзэл санаатай холбоотой байж болох бөгөөд зарим судлаачид булш оршуулгад зос цацах нь цусыг төлөөлүүлсэн эртний зан үйл гэж үздэг (Наваан, 1975:133). Энэ хожмын бөө нарын эд хэрэглэл дээр, тухайлбал бөөгийн хэц дээрх улаан зосоор зурсан буга (Наваан, 1975:133) болон бусад дүрсүүд, Монгол (Bayarsaikhkan, 2005: 44-45), Сибирийн (Konovalov, 2006; Hoppal, 2007: 64) бөө нарын хэнгэрэг дээрх улаан зосон дүрсүүдтэй үзэл санааны үүтгэл нэгтэй болов уу. Өөрөөр хэлбэл, бөө нарын эдлэл хэрэглэл түүн дээрх дүрс бэлгэдлүүд нь "амьд", харанхуйн оронд мөнхөрч буй утга, үзэл санааг агуулдаг байна (Пүрэв, 1999:244-260). Тиймээс буган хөшөөн дээрх улаанаар зосодсон буга болон бусад дүрслэлийн адил буган хөшөөний сийлбэр дүрсүүдийг улаанаар зосдох нь тухайн амьтад, эд зүйлсийг "амилуулж" (Дулам, 2014: 50), "мөнхрүүлж" буй утга агуулгыг илтгэсэн бололтой.

Ийнхүү бид Монголын баруун хойд бүс нутаг Увс аймгийн Зүүнхангай сумын нутгаас урь өмнө тодорхой хэмжээнд судлагдсан болон шинээр бүртгэн баримтжуулсан нийт 32 буган хөшөөний бүрэн тодорхойлолт, тэдгээрийн тархалт, байршил, ангилал, дүрслэлийн онцлог зэргийг энэхүү судалгаанд авч үзлээ.

Ном зүй

Баярсайхан, 2017 – Ж. Баярсайхан Монголын умард нутгийн буган хөшөөд. Улаанбаатар, 2017.

Баярсайхан нар, 2015 – Баярсайхан Ж, Жан-Лүүк Хюль, Ч.Баяндэлгэр, Оула Сэйцонин. Ли Бродерик. Монгол-Америкийн хамтарсан "Баруун Монгол" төслийн 2015 оны археологийн хээрийн судалгааны тайлан. Улаанбаатар, 2015. Монголын үндэсний музейн номын сан.

Баярсайхан нар, 2017 – Баярсайхан Ж, Жан-Лүүк Хюль, Т.Түвшинжаргал. Монгол-Америкийн хамтарсан "Баруун Монгол" төслийн 2017 оны хээрийн судалгааны тайлан. Улаанбаатар, 2018. Монголын үндэсний музейн номын сан.

Баярсайхан нар, 2018 – Монгол-Америкийн хамтарсан "Баруун Монгол" төслийн 2018 оны хээрийн судалгааны тайлан. Улаанбаатар, 2015. Монголын үндэсний музейн номын сан.

Баярсайхан нар, 2023 – Ж.Баярсайхан, Жан-Лүүк Хюль, Г.Бүрэнтөгс, Оула Сэйцонен, Наталиа Экүүз, Франческо Конеса, Сара Плогер, Г.Нямбат. Монгол-Америкийн хамтарсан "Баруун Монгол" төслийн 2023 оны археологийн хээрийн судалгааны тайлан. Улаанбаатар, 2023. Монголын үндэсний музейн номын сан.

Дулам, 2014 – С.Дулам. Монгол бэлгэдэл зүй. II дэвтэр: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зуй. Улаанбаатар, 2000.

Есин и др, 2014 – Ю.Н.Есин, Ж.Магай, Э.Руссельер, Ф.Вальтер Краска в наскальном искусствеокуневской культуры Минусинской котловины.// Российская археология, 2014, No 3, с. 79–88.

Идэрхангай нар, 2023 – Т.Идэрхангай, АА.Тишкин, В.В.Горбунов, Ю.М.Свойский, С.Ю.Бондаренко, Д.Цэнд, П.Эрдэнэпүрэв, О.С.Пихачева, А.Л.Тишкин (бага), Ж.Энхзул. Монгол-Оросын хамтарсан экспедицийн Архангай аймгийн Батцэнгэл сумын нутагт орших хөшөөн дэнж хэмээх газарт явуулсан буган хөшөөний баримтжуулалт, малтлага судалгаа. // Монголын археологи-2023. Улаанбаатар, 2023. Тал. 153-157.

Ковалев, Эрдэнэбаатар, 2021 – А.А.Ковалев, Д.Эрдэнэбаатар. Оленные камни в ритуале древних кочевников Монголии. Хар говь, Суртийн дэнж. Санкт-Петербург. 2021.

Наваан, 1975 – Д.Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. Улаанбаатар, 1975.

Нямбат, Одбаатар, 2010 – М.Нямбат, Ц.Одбаатар. Зүүнхангай сумын нутгаас шинээр олдсон буган хөшөөд. //Нүүдэлчдийн өв судлал. Том X, Fasc 4. УБ., 2010, т. 57-66.

Нямбат, 2016 – М. Нямбат. Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг дахь археологийн дурсгалууд. Улаанбаатар, 2016.

Пүрэв, 1999 – О.Пүрэв. Монгол бөөгийн шашин. Улаанбаатар, 1999.

Тишкин, 2013а – А.А.Тишкин. Выявление, документирование и изучение «оленных» камней в долине Буянта (Монгольский Алтай) // Теория и практика археологических исследований. 2013. № 1 (7). С. 73–90.

Тишкин, 2013б – А.А.Тишкин. Оленные камни Центральной Азии и изображения на них: обзор существующих интерпретаций и новые открытия // Творчество в археологическом и этнографическом измерении. Омск: Наука, 2013. С. 222–228.

Bayarsaikhan, 2005 – J.Bayarsaikhan. Shamanistic Elements in Mongolian Deer Stone Art. The Deer Stone Project: Anthropological Studies in Mongolia 2002-2004. Edited by William W. Fitzhugh, J. Bayarsaikhan, and Peter K. Marsh. Arctic Studies Center and the National Museum of Mongolian History. Washington and Ulaanbaatar, 2005. Pp 41-46.

Esin et al, 2017 – Y. Esin, J. Magail, C. Yeruul-Erdene, J. Gantulga. Paint on Deer Stones of Mongolia. Archaeology Ethnology & Anthropology of Eurasia, 2017, 45 (3), pp.79-89.

Konovalov, 2006 – Senior Editor: Alexei Konovalov. Editors. Valentina Gorbacheva, Kanna Solovyeva .Between the Worlds: Shamanism of the Peoples of Siberia [from the Collection of the Russian Museum of Ethnography: an Album]. Moscow: Khudozhnik i Kniga Publishers, 2006. 296 pages, illustrated.

Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.
See: http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/

ХАВСРАЛТ ЗУРАГ

Зураг 1. Бүлцэнгийн үзүүрийн буган хөшөөд.

Зураг 2. Хүрдлэгийн амны 1 (А) ба 2 (Б) дугаар буган хөшөө

Зураг 3. Хүрдлэгийн амны 3 (А), 4 (Б), 5 (В), 6 (Г), 7 (Д) дугаар буган хөшөөд

Зураг 4. Хүрдлэгийн амны 8 (А), 9 (Б) дүгээр буган хөшөөд

Зураг 5. Хужирын улаан толгойн 1 (А), 2 (Б), 3 (В) дугаар буган хөшөөд

Зураг 6. Гялгарын бэлийн 1 дүгээр буган хөшөө

Зураг 7. Гялгарын бэлийн 2 дугаар буган хөшөө

Зураг 8. Цавдан нуурын арын 1 (А), 2 (Б) дугаар буган хөшөө

Зураг 9. Хүйс толгойн буган хөшөө

Зураг 10. Хөх голын 1 дүгээр буган хөшөө

Зураг 11. Хөх голын 2 дугаар буган хөшөө

Зураг 12. Зүүнхангай сумын төвийн буган хөшөө

Зураг 13. Дөрөлжийн хөшөөтийн 1 (зүүн гар талын), 2 дугаар буган хөшөө

Зураг 14. Далан булагийн буган хөшөө

Зураг 15. Их гол-1 буган хөшөө

Зураг 16. Их гол-2 буган хөшөө

Зураг 17. Тэгш буянтын хөндийн 1 (А), 2 (Б) дугаар буган хөшөө

Зураг 18. Зүүнхангай сумын нутаг дахь буган хөшөө бүхий дурсгалт газруудын байршил

Зураг 19. Буган хөшөөний ангиллыг харуулсан бүдүүвч

Зураг 20. Буган хөшөөдийн өндрийг харуулсан бүдүүвч

Зураг 21. Буган хөшөөдийн дээд хэсгийн дүрслэлийн тоон үзүүлэлтийг харуулсан бүдүүвч

Зураг 22. Буган хөшөөдийн зэр зэвсэг, эд зүйлсийн дүрслэлийн тоон үзүүлэлт

Зураг 23. Буган хөшөөдийн бүсний дүрслэл, хээний тоон үзүүлэлт

Зураг 24. Дөрөлжийн хөшөөтийн 2 дугаар буган хөшөөний бүс болон сүхний сийлбэрт хадгалагдаж үлдсэн зос. iDStretch программаар тодруулсан байдал.